



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/380

Алтай хот

Төв суурин газрын өвөлжилтийн
бэлтгэлийг хангах ажлын хэсэг байгуулах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2022-2023 оны төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гаргаж, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулж хэрэгжилтийг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Чинбат)-д даалгасугай.

3.Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, хамтран ажиллахыг албан байгууллагын дарга, захирал, эрхлэгч, сумдын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20²² оны
06 дугаар сарын 24-ний өдрийн 7/28 дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

(Алтай хотын захирагч бөгөөд Есөнбулаг сумын
Засаг дарга)

(Онцгой байдлын газрын дарга)

(Мэргэжлийн хяналтын газрын дарга)

(Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны
гишүүн)

(“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн
захирал)

(“Ундарга-Алтай” ААТҮГ-ын захирал)

(“Солонго дулааны станц” ААТҮГ-ын захирал)

(“Мандал-голомт” ХХК-ийн захирал)

(Сумдын Засаг дарга нар)

(Хэрэглэгчид)

Нарийн бичгийн дарга: (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга)

__oOo__